

БАТЛАВ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГА *А.Эрдэнэсайхан*

БАТЛАВ
“БАЯН ХАРААТ” ХХК-НЫ
БАЯН ХАРААТ
ЗАХИРАЛ *Ч.Ширчинжав*
0820030006 № 3436314

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМАНД “ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
УРЛАГ ЗААЛНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” -ИЙН АЖЛЫН ГЭРЭЭ
ДУГААР № ДУГАЦДСЗДТГ/202301001

2023.05.22

Хараат

Нэг талаас (цаашид “Захиалагч” гэх) Засаг дарга А.Эрдэнэсайхан, нөгөө талаас “Баянхараат” ХХК-ны захирал Ч.Ширчинжав (цаашид “Гүйцэтгэгч”гэх) нар дараах зүйлсийг харилцан тохиролцож 2023 оны 05 дугаар сарын 22 -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын “Хүүхдийн цэцэрлэгийн урлаг заалны тоног төхөөрөмж” нийлүүлэх ажлыг ДУГАЦДСЗДТГ/202301001 дугаартай (цаашид “гэрээний үүрэг” гэх) 2,960,000 (Хоёр сая есөн зуун жаран мянга)-н төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь “Хүүхдийн цэцэрлэгийн урлаг заалны тоног төхөөрөмж” нийлүүлэх ажлын 2,960,000 (Хоёр сая есөн зуун жаран мянга)-н төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.
4. Гүйцэтгэг нь тус сумын “Хүүхдийн цэцэрлэгийн урлаг заалны тоног төхөөрөмж” нийлүүлэх ажлыг техникийн тодорхойлолтонд заагдсан нөхцлийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Ажлыг 2023 оны 05 дугаар сарын 23 -ны өдөр эхлүүлж 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор гүйцэтгэнэ.
5. Санхүүжилтийг ажлын гүйцэтгэл дууссаны дараа ажлын 5 хоногийн дотор санхүүжилт 100% хийгдэнэ.

6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 6.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 6.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 6.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал;
- 6.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 6.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 6.6 Ажлын зураг, техникийн тодорхойлолт
- 6.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь
- 6.8 Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.
10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
11. Ажлыг батлагдсан зургийн дагуу гүйцэтгэх ба гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээнээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.

12. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд saat ал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЦАГААНДЭЛГЭР СҮМЫН

ХҮҮХДИЙН ЦЭДЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ

Д.Сарантүяа
Д.САРАНТҮЯА

ХАЯГ: Дундговь аймгийн Цагаандэлгэр

сум Хараат 1-р баг

Утас: 89124077

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“БАЯН ХАРААТ” ХХК-НЫ

ТӨЛӨӨЛӨЛ

Э.Янжинлхам
Э.ЯНЖИНЛХАМ

ХАЯГ: Дундговь аймаг Цагаандэлгэр

сумын төв 1-р баг

Харилцах банк: ХААН: 5466172350

Регистрийн дугаар: 3436314

Утас: 88780950